



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 8/787

Арвайхээр

Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3, Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.7, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны "Аймгийн 2019 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" 12/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төсвөөс сум, байгууллагат олгох санхүүгийн дэмжлэгийн хуваарийг нэгдүгээр, ерөнхий боловсролын байгууллагын хуваарийг хоёрдугаар, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын хуваарийг гуравдугаар, эрүүл мэндийн анхан шатны байгууллагын хуваарийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Төсвийн санхүүжилтийг батлагдсан хуваарийн дагуу олгож, төсвийн зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 "Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай" А/635 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011101497